

Цацрагийн түвшний 2024 оны 09 сарын төлөв

Завхан аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн Улиастай сумын Улиастай-01, Баянтэс сумын Баян-уул өртөөдөд **RDS-110** багажаар тус тус цацрагийн түвшний хэмжилтийг өдөр бүр 08 болон 14 цагуудад тогтмол хэмжилт хийж байна.

09 дүгээр сарын хэмжилтийн дүнгээс харахад: Цацрагийн түвшний хамгийн их утга 0.14 микрозиверт/цаг, бага утга нь 0.08 микрозиверт/цаг байна.

Улиастай, Баянтэс сумдын 09 сарын агаар болон газрын гадарга дах цацрагийн түвшний тунгийн чадлын өдрийн дундаж утгийг графикаар харуулав.




График 1. Улиастай сумын агаар болон газрын гадарга дах цацрагийн түвшний тунгийн чадлын өдрийн дундаж утга




График 2. Баянтэс сумын агаар болон газрын гадарга дах цацрагийн түвшний тунгийн чадлын өдрийн дундаж утга

*Улиастай өртөөний агаар болон газрын гадарга дах цацрагийн түвшний тунгийн чадлын өдрийн дундаж утгийг өмнөх онтой харьцуулснаар дараах графикаар харуулав.




График3. Улиастай сумын 2023, 2024 оны цацрагийн хэмжилтийн утга

Хэмжилтийн дүнгээс харахад 2023 онд агаар дах цацрагийн түвшний дунджийн хамгийн их утга нь 0.12 микрозиверт/цаг, хамгийн бага утга нь 0.09 микрозиверт/цаг байсан бол 2024 онд дунджийн хамгийн их утга нь 0.12 микрозиверт/цаг, хамгийн бага утга нь 0.10 микрозиверт/цаг байна. Мөн 2023 онд газрын гадарга дах цацрагийн түвшний дунджийн хамгийн их утга нь 0.12 микрозиверт/цаг, хамгийн бага нь 0.10 микрозиверт/цаг байсан бол 2024 онд дунджийн хамгийн их утга нь 0.12 микрозиверт/цаг, хамгийн бага утга нь 0.10 микрозиверт/цаг байна.

*Баянтэс сумын Баян-Уул өртөөний агаар болон газрын гадарга дах цацрагийн түвшний тунгийн чадлын өдрийн дундаж утгыг өмнөх онтой харьцуулснаар дараах графикаар харуулав.




График4. Баянтэс сумын 2023, 2024 оны цацрагийн хэмжилтийн утга

Хэмжилтийн дүнгээс авч үзвэл 2023 онд агаар дах цацрагийн түвшний дунджийн хамгийн их утга нь 0.12 микрозиверт/цаг, хамгийн бага утга нь 0.10 микрозиверт/цаг байсан бол 2024 онд дунджийн хамгийн их утга нь 0.11 микрозиверт/цаг, хамгийн бага утга нь 0.09 микрозиверт/цаг байна. Мөн хэмжилтийн дүнгээс харвал 2023 онд газрын гадарга дах цацрагийн түвшний дунджийн хамгийн их утга нь 0.12 микрозиверт/цаг, хамгийн бага нь 0.10 микрозиверт/цаг байсан бол 2024 онд дунджийн хамгийн их утга нь 0.12 микрозиверт/цаг, хамгийн бага утга нь 0.08 микрозиверт/цаг байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг <https://www.eic.mn/radiation/> мэдээллийн сангаас харах боломжтой.

2024 ОН